



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Биатлоны Үндэсний шигшээ багийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биатлоны Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 08 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын Биатлоны холбоонд үүрэг болгосугай.

3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын Биатлоны холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА

142410151

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны  
өдрийн 157 дугаар тушаалын хавсралт

БИАТЛОНЫ ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог       | Нэр         | Үүрэг         |
|---|------------|-------------|---------------|
| 1 | Баттүвшин  | Бат-Эрдэнэ  | Дасгалжуулагч |
| 2 | Цэдэвдорж  | Мөнх-Эрдэнэ | Дасгалжуулагч |
| 3 | Болдбаатар | Анхболд     | Тамирчин      |
| 4 | Энхбат     | Энхсайхан   | Тамирчин      |
| 5 | Жаргал     | Гантулга    | Тамирчин      |
| 6 | Мөнхбат    | Должинсүрэн | Тамирчин      |
| 7 | Даваадулам | Энхчимэг    | Тамирчин      |
| 8 | Хүрэлээ    | Сумъяа      | Тамирчин      |

--oOo--